

ЦӨМИЙН ЗЭВСГИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ГЭРЭЭ

Энэхүү гэрээний Оролцогч улсууд нь,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн зорилго, зарчмуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахад шийдвэр төгс байж,

Цөмийн зэвсгийг аливаа байдлаар хэрэглэснээс үүдэн гарах хүмүүнлэгийн сүйрлийн үр дагаварт сэтгэл гүнээ зовниж, цөмийн зэвсгийг бүрэн устгах нэн шаардлага нь ийм зэвсгийг ямар ч нөхцөлд, дахин хэзээ ч хэрэглэхгүй байх цорын ганц баталгаа болохыг хүлээн зөвшөөрч,

Цөмийн зэвсгийг үргэлжлүүлэн хадгалж байгаагаас учрах, тэр дундаа гэнэтийн осол, алдаатай тооцоо, эсхүл зохион бүтээснээс шалтгаалан цөмийн зэвсгийн аливаа дэлбэрэлт үүсэх эрсдэлийг санаж, эдгээр эрсдэл нь нийт хүн төрөлхтний аюулгүй байдалд хамааралтайг, мөн бүх улс орнууд цөмийн зэвсгийг аливаа хэлбэрээр хэрэглэхээс урьдчилан сэргийлэх үүрэг хариуцлагыг хамтран хүлээн гэдгийг онцлон тэмдэглэж,

Цөмийн зэвсгийн сүйрлийн үр дагаврыг зохих түвшинд бүрэн арилгаж чадахгүй бөгөөд улс хоорондын хил хязгаарыг давж, хүний эсэн мэнд амьдрах, байгаль орчин, нийгэм-эдийн засгийн хөгжил, дэлхийн эдийн засаг, хүнсний аюулгүй байдал, өнөөгийн болон хойч үеийнхний эрүүл мэндэд ноцтой үр дагавар учруулж, ялангуяа, ионжуулагч цацрагийн үр нөлөөгөөр охид эмэгтэйчүүдэд харьцуулашгүй сөрөг нөлөө үзүүлэхийг ухамсарлан ойлгож,

Цөмийн зэвсгийг хураах ёс зүйн шаардлага байгааг зөвшөөрч, үндэсний болон хамтын аюулгүй байдлын ашиг сонирхлын аль алинд нь нийцсэн дэлхий нийтийн хүсэл эрмэлзэл болох цөмийн зэвсгээс ангид дэлхий ертөнцийг бий болгох, хадгалж хамгаалах нь нэн тэргүүний тулгамдсан асуудал болохыг хүлээн зөвшөөрч,

Цөмийн зэвсэг хэрэглэсний улмаас хохирсон хохирогчид (хибакуша нар), түүнчлэн цөмийн зэвсгийн туршилтад өртсөн тэдэнд хүлээн зөвшөөрөх боломжгүй зовлон, хохирол учирсныг санаж,

Цөмийн зэвсэгтэй холбоотой үйл ажиллагааны улмаас уугуул иргэдэд харьцуулашгүй сөрөг нөлөөл үзүүлж буйг хүлээн зөвшөөрч,

Бүх улс хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын эрх зүй, түүний дотор олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг байнга дагаж мөрдөх шаардлагатайг дахин нотолж,

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зарчим, хэм хэмжээнд, тухайлбал, зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талуудын байлдааны арга, эсхүл хэрэгслээ сонгох эрх нь хязгааргүй биш гэсэн зарчим, байлдагч, энгийн иргэнийг ялгах журам, байлдааны бус зориулалтаар дайралт хийхийг хориглох, дайралтад тохирсон, урьдчилан анхааруулах журам, үлэмж гэмтэл, эсхүл бага хохирол учруулахуйц шинжтэй зэвсэг хэрэглэхийг хориглох, байгаль орчныг хамгаалах журмыг үндэслэн,

Цөмийн зэвсгийг аливаа хэлбэрээр хэрэглэх нь зэвсэгт мөргөлдөөний үед дагаж мөрдөх олон улсын эрх зүйн хэм хэмжээ, ялангуяа олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зарчим, хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл хэмээн үзэж,

Цөмийн зэвсгийг аливаа байдлаар хэрэглэх нь хүмүүнлэгийн зарчим, нийтийн ухамсрын шаардлагад ч мөн үл нийцнэ гэдгийг нотолж,

Монгол Улсын Гадаад харилцааны яам

АЛБАН БУСНЬ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature

2011 оны 06 сарын 03 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Улсууд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн дагуу улс хоорондын харилцаанд аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс төрийн бие даасан байдлын эсрэг хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилготой үл нийцэх бусад үйлдлээс татгалзах ёстой бөгөөд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг тогтоох, хадгалж хамгаалахдаа дэлхийн хүний болон эдийн засгийн нөөцийг зэвсэглэлд хамгийн бага хэмжээгээр чиглүүлэх ёстойг санаж,

1946 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн анхны тогтоол, цөмийн зэвсгийг устгахыг уриалсан дараа дараагийн тогтоолуудыг мөн санаж,

Цөмийн зэвсэг хураах явц удаан өрнөж байгаад, цэргийн болон аюулгүй байдлын үзэл баримтлал, номлол, бодлогод цөмийн зэвсгийн талаар найдлага тавьсаар байгаад, мөн эдийн засгийн болон хүний нөөцийг цөмийн зэвсгийн үйлдвэрлэл, хадгалалт, шинэчлэл хийхэд зарцуулж буйд санаа зовниж,

Заавал дагаж мөрдөх эрх зүйн аргаар цөмийн зэвсгийг хориглох нь дэлхий ертөнцийг цөмийн зэвсгээс бүрэн ангижруулах, бататган хамгаалах, тэр дундаа цөмийн зэвсгийг устгах үйл явцыг эргэлт буцалтгүйгээр, хяналттай, ил тод хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр болно гэдгийг хүлээн зөвшөөрч, энэ чиглэлээр ажиллахад шийдвэр төгс байж,

Олон улсын хатуу чанд, үр нөлөөтэй хяналтын дор зэвсгийг бүх нийтээр, бүрэн хураах чиглэлд үр дүнтэй, ахиц дэвшил гаргахуйц арга хэмжээ авахад шийдвэр төгс байж,

Олон улсын хатуу чанд, үр нөлөөтэй хяналтын дор цөмийн зэвсгийг түүний бүхий л асуудлынх нь хүрээнд хураахад чиглэсэн яриа хэлэлцээг үнэнч шударгаар явуулах, үр дүнд хүргэх үүрэгтэй болохыг дахин нотолж,

Цөмийн зэвсэг хураах, үл дэлгэрүүлэх дэглэмийн үндэс болсон Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээг бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэнэ гэдгийг дахин нотолж,

Цөмийн зэвсэг хураах, үл дэлгэрүүлэх дэглэмийн үндсэн бүрэлдэхүүн болох Цөмийн туршилтыг бүрэн хориглох тухай гэрээ, түүний хяналтын дэглэмийн онцгой ач холбогдолыг хүлээн зөвшөөрч,

Бүс нутгийн холбогдох улсууд сайн дурын үндсэн дээр тохиролцож, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн цөмийн зэвсгээс ангид бүсүүдийг байгуулсан нь дэлхийн болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлж, цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх дэглэмийг бататган, цөмийн зэвсэг хураах зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байгаагаа дахин нотолж,

Энэхүү гэрээний аль ч заалт нь цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор, үл ялгаварлах үүднээс судалгааг хөгжүүлэх, үйлдвэрлэл явуулах, ашиглах тухай Оролцогч улсуудын салшгүй эрхийг хөндөнө хэмээн тайлбарлах ёсгүйг онцлон тэмдэглэж,

Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрх тэгш, бүрэн, идэвхтэй оролцоо нь энх тайван, аюулгүй байдлыг тогтвортой хангах, бэхжүүлэхэд чухал хүчин зүйл гэдгийг хүлээн зөвшөөрч, цөмийн зэвсгийг хураахад эмэгтэйчүүдийн идэвхтэй оролцоог дэмжиж, бэхжүүлэхээ нотолж,

Энх тайван, зэвсэг хураах боловсролын бүхий л салбар, цөмийн зэвсгийн эрсдэл, үр дагаврын талаарх ойлголтыг өнөөгийн болон хойч үедээ түгээхийн чухалыг мөн хүлээн зөвшөөрч, энэхүү гэрээний зарчим, хэм хэмжээг түгээн дэлгэрүүлэх үүрэг хүлээж байгаагаа нотолж,

Гарын үсэг /Signature/

2011 оны 11 сарын 14 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Цөмийн зэвсгийг бүрэн устгах уриалгаар нотлогдож байгаа хүмүүнлэгийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд олон нийтийн ухамсар чухал үүрэгтэйг тэмдэглэж, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар хөдөлгөөн, олон улсын болон бүс нутгийн бусад байгууллага, төрийн бус байгууллагууд, шашны удирдагчид, парламентын гишүүд, эрдэмтэн судлаачид, хибакуша нарын энэ чиглэлд гаргаж буй хүчин чармайлтыг үнэлж дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл Хориглох зүйлс

1. Оролцогч улс бүр хэзээ ч, ямар ч нөхцөлд дараах арга хэмжээг авахгүй. Үүнд:

а) цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмж боловсруулах, турших, гаргаж авах, үйлдвэрлэх, өөр арга замаар олж авах, эзэмших, эсхүл нөөцлөх;

б) цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмжийг хүлээн авагч аль нэг талд шилжүүлэх, эсхүл ийм зэвсэг, тэсрэх төхөөрөмжийг шууд буюу шууд бусаар хянах;

в) цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмжийг шилжүүлэн авах, шууд буюу шууд бусаар хянах;

г) цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмжийг хэрэглэх, эсхүл хэрэглэхээр заналхийлэх;

(д) энэхүү гэрээний дагуу Оролцогч улсад хориглосон аливаа үйл ажиллагаанд аль нэг этгээд оролцоход ямар нэгэн байдлаар туслах, дэмжих, эсхүл өдөөн турхирах;


е) энэхүү гэрээний дагуу Оролцогч улсад хориглосон аливаа үйл ажиллагаанд оролцохоор аль нэг этгээдээс ямар нэгэн байдлаар аливаа тусламж хүсэх, эсхүл авах;

ё) цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмжийг өөрийн нутаг дэвсгэрт, эсхүл өөрийн харьяалал буюу хяналтад нь байдаг аль нэг газарт байрлуулах, суурилуулах, эсхүл байршуулахыг зөвшөөрөх.

2 дугаар зүйл Мэдэгдэл

1. Оролцогч улс бүр энэхүү гэрээ нь тухайн Оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад дараах зүйлийг тусгасан мэдэгдэл хүргүүлнэ. Үүнд:

(а) Энэхүү гэрээ Оролцогч тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болохоос өмнө цөмийн зэвсэг, эсхүл цөмийн тэсрэх төхөөрөмж эзэмшиж байсан, мэдэлдээ буюу хяналтдаа байлгаж байсан эсэх, цөмийн зэвсгийн хөтөлбөрөө түүний дотор цөмийн зэвсэгтэй холбоотой бүх байгууламжаа устгасан, эсхүл эргэлт буцалтгүйгээр хөрвүүлсэн эсэхээ зарлан мэдэгдэх;



(б) 1 дүгээр зүйлийн (а) заалтаас үл хамааран аливаа цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмж эзэмшиж байгаа, мэдэлдээ буюу хяналтдаа байлгаж байгаа эсэхээ зарлан мэдэгдэх;

(в) 1 дүгээр зүйлийн (ё) заалтаас үл хамааран өөрийн улсын нутаг дэвсгэрт эсхүл өөрийн харьяалалд буюу хяналтад нь байдаг газарт, эсхүл нөгөө улсын эзэмшдэг, мэдэлд нь буюу хяналтад нь байдаг нутаг дэвсгэрт цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмж байгаа эсэхийг зарлан мэдэгдэх.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авсан бүх мэдэгдлийг Оролцогч улсуудад хүргүүлнэ.

3 дугаар зүйл Баталгаа

1. Гэрээний 4 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалт хамаарахгүй Оролцогч улс бүр наад зах нь энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөж байсан Олон улсын атомын энергийн агентлагийн Иж бүрэн баталгааны хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хадгалж үлдээх ба энэ нь цаашид баталж болох аливаа холбогдох нэмэлт баримт бичигт сөргөөр нөлөөлөхгүй.

2. Гэрээний 4 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалт хамаарахгүй Оролцогч улс бүр Олон улсын атомын энергийн агентлагтай бүх талыг хамарсан Иж бүрэн баталгааны хэлэлцээр (INFCIRC/153 (Засварласан)) байгуулаагүй бол тийм хэлэлцээрийг түүнтэй байгуулж хүчин төгөлдөр болгоно. Ийм хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг тухайн Оролцогч улсын хувьд энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 180 хоногийн дотор эхлүүлнэ. Тэрхүү хэлэлцээр нь тухайн Оролцогч улсын хувьд энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 18 сарын дотор хүчин төгөлдөр болно. Улмаар Оролцогч улс бүр хэлэлцээрээр хүлээсэн үүргээ өөртөө хадгалж үлдээх ба энэ нь ирээдүйд баталж болох аливаа холбогдох нэмэлт баримт бичигт сөргөөр нөлөөлөхгүй.

4 дүгээр зүйл Цөмийн зэвсгийг бүрэн устгахын төлөө

1. 2017 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөс хойш цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмжийг эзэмшсэн, мэдэлдээ, эсхүл хяналтдаа байлгаж байсан ба энэхүү гэрээ тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болохоос өмнө цөмийн зэвсгийн хөтөлбөрөө, түүний дотор цөмийн зэвсэгтэй холбоотой бүх байгууламжаа устгасан, эсхүл эргэлт буцалтгүйгээр хөрвүүлсэн Оролцогч улс бүр өөрийн цөмийн зэвсгийн хөтөлбөрөө эргэлт буцалтгүйгээр устгасан эсэхийг магадлан шалгуулах зорилгоор энэ зүйлийн 6 дахь заалтын дагуу томилогдох олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана. Олон улсын эрх бүхий байгууллага нь тайлангаа Оролцогч улсуудад хүргүүлнэ. Тийм Оролцогч улс нь зарласан цөмийн материалыг энхийн зорилгоор явуулж буй цөмийн үйл ажиллагаанаас өөр зорилгод ашиглахгүй байх, Оролцогч улсад бүхэлдээ зарлагдаагүй цөмийн материал, эсхүл үйл ажиллагаа байхгүй гэсэн найдвартай баталгаа гаргахад хангалттай Иж бүрэн баталгааны хэлэлцээрийг Олон улсын атомын энергийн агентлагтай байгуулна. Ийм хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг тухайн Оролцогч улсын хувьд энэ гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 180 хоногийн дотор эхлүүлнэ. Тухайн Оролцогч улсын хувьд энэ гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 18

2017 оны 06 сарын 07 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL OF ATTESTATION

сарын дотор тэрхүү хэлэлцээр нь хүчин төгөлдөр болно. Улмаар Оролцогч улс наад зах нь эдгээр баталгаа гаргах үүргээ өөртөө хадгалж үлдэх ба энэ нь ирээдүйд баталж болох аливаа холбогдох нэмэлт баримт бичигт сөргөөр нөлөөлөхгүй.


2. Гэрээний 1 дүгээр зүйлийн (а) заалтаас үл хамааран цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмж эзэмшдэг, мэдэлдээ, эсхүл хяналтдаа байлгадаг Оролцогч улс бүр тэдгээрийг ажиллагааны бэлэн байдлаас нь нэн даруй гаргаж, аль болох богино хугацаанд, гэхдээ Оролцогч улсуудын анхны уулзалтаас тогтоосон цаад хугацаанаас хэтрүүлэлгүй устгах ба энэ ажлыг Оролцогч улсын цөмийн зэвсгийн хөтөлбөрийг хяналтын дор эргэлт буцалтгүйгээр устгах, тэр дундаа цөмийн зэвсэгтэй холбоотой бүх байгууламжийг устгах буюу эргэлт буцалтгүйгээр хөрвүүлэх ажлыг заавал дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ, тодорхой цаг хугацаат төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ. Оролцогч улс төлөвлөгөөгөө тухайн Оролцогч улсын хувьд энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 60 хоногийн дотор Оролцогч улсуудад, эсхүл тэдний томилсон олон улсын эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. Улмаар төлөвлөгөөг олон улсын эрх бүхий байгууллагатай хэлэлцэн тохиролцож, Оролцогч улсуудын дараагийн уулзалт, эсхүл аль түрүүлж болох хянан хэлэлцэх бага хуралд хүргүүлж, холбогдох журмын дагуу батлуулна.

3. Дээрх 2 дахь заалт хамаарах Оролцогч улс зарласан цөмийн материалаа энхийн зорилгоор явуулж буй цөмийн үйл ажиллагаанаас өөр зорилгод ашиглахгүй байх, тухайн улсад бүхэлдээ зарлагдаагүй цөмийн материал, эсхүл үйл ажиллагаа байхгүй гэдэгт найдвартай баталгаа гаргах үүднээс Олон улсын атомын энергийн агентлагтай Иж бүрэн баталгааны хэлэлцээр байгуулна. Ийм хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг 2 дахь заалтад дурдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж дуусах өдрөөс хэтрүүлэхгүйгээр эхлүүлнэ. Тэрхүү хэлэлцээр нь яриа хэлэлцээ эхэлсэн өдрөөс хойш 18 сарын дотор хүчин төгөлдөр болно. Улмаар тухайн Оролцогч улс наад зах нь эдгээр баталгаа гаргах үүргээ өөртөө хадгалж үлдэх ба энэ нь ирээдүйд баталж болох аливаа холбогдох нэмэлт баримт бичигт сөргөөр нөлөөлөхгүй. Энэ хэсэгт дурдсан хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа Оролцогч улс энэ зүйлд заасан үүргээ биелүүлсэн тухай сүүлчийн мэдэгдлээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

4. 1 дүгээр зүйлийн (б) ба (ё) заалтаас үл хамааран өөрийнх нь нутаг дэвсгэрт, эсхүл харьяалал буюу хяналтад нь байдаг газар нутагт өөр улсын эзэмшдэг, мэдэлд нь буюу хяналтад нь байдаг цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмж байгаа бол Оролцогч улс бүр тэдгээрийг аль болох богино хугацаанд, чингэхдээ Оролцогч улсуудын анхны уулзалтаас тогтоосон хугацаанаас хэтрүүлэхгүйгээр, нэн даруй гаргах ажлыг ханган хэрэгжүүлнэ. Ийм зэвсэг, эсхүл бусад төрлийн тэсрэх төхөөрөмжийг гаргасны дараа Оролцогч улс нь энэ зүйлд заасан үүргээ биелүүлсэн тухай мэдэгдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

5. Энэ зүйл өөрт нь хамаарах Оролцогч улс бүр энэхүү зүйлд заасан үүргээ хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшлийн талаарх тайланг Оролцогч улсуудын ээлжит уулзалт болон хянан хэлэлцэх бага хурал бүрт үүргээ бүрэн хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд хүргүүлнэ.

6. Оролцогч улсууд нь цөмийн зэвсгийн хөтөлбөрийг эргэлт буцалтгүйгээр устгах, тэр дундаа цөмийн зэвсэгтэй холбоотой бүх байгууламжийг энэ зүйлийн 1, 2, 3 дахь заалтад заасны дагуу устгах буюу эргэлт буцалтгүйгээр хөрвүүлэх асуудлаар яриа хэлэлцээ хийх, магадлан шалгах олон улсын эрх бүхий байгууллага, эсхүл байгууллагуудыг томилно. Хэрэв энэ зүйлийн 1, эсхүл 2 дахь заалт хамаарах Оролцогч улсын хувьд энэхүү гэрээ хүчин төгөлдөр болохоос



өмнө ийм томилгоо хийгдээгүй бол Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга аливаа шаардлагатай шийдвэр гаргуулах үүднээс Оролцогч улсуудын ээлжит бус уулзалтыг зарлан хуралдуулна.

5 дугаар зүйл Үндэсний хэрэгжилт

1. Оролцогч улс бүр энэхүү гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг батална.

2. Оролцогч улс бүр өөрийн харьяалал буюу хяналтад нь байдаг нутаг дэвсгэрт, эсхүл тэнд байгаа хүмүүсийн зүгээс энэхүү гэрээгээр Оролцогч улсад хориглосон аливаа үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд бүхий л зохих эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээ, түүний дотор торгуулийн шийтгэл ногдуулах арга хэмжээ авна.

6 дугаар зүйл Хохирогчдод үзүүлэх тусламж, байгаль орчны нөхөн сэргээлт

1. Оролцогч улс бүр цөмийн зэвсэг хэрэглэх, эсхүл туршихад өртсөн өөрийн харьяаллын хүмүүст олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хүчин төгөлдөр хуулийн дагуу аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр зохих ёсоор нас, хүйсэд нь тохирсон тусламжийг түүний дотор эмнэлгийн тусламж, нөхөн сэргээх болон сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх, мөн тэднийг нийгэм, эдийн засгийн амьдралд оролцуулах явдлыг хангана.

2. Оролцогч улс бүр цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмжийг турших, эсхүл хэрэглэхтэй холбоотой үйл ажиллагааны үр дүнд бохирдож сүйдсэн өөрийн харьяалал, буюу хяналтад нь байдаг газар нутгийн хувьд бохирдож сүйдсэн орчны нөхөн сэргээлтэд шаардлагатай зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3. Дээрх 1, 2 дахь заалтын дагуу хүлээх үүрэг нь аливаа бусад улсын олон улсын эрх зүйн, эсхүл хоёр талын гэрээнд заасан үүрэг, хариуцлагад сөргөөр нөлөөлөхгүй.

7 дугаар зүйл Олон улсын хамтын ажиллагаа, тусламж

1. Оролцогч улс бүр энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс Оролцогч бусад улстай хамтран ажиллана.

2. Энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхдээ Оролцогч улс бүр боломжтой бол Оролцогч бусад улсаас тусламж хүсэх болон авах эрхтэй байна.

3. Оролцогч улс бүр өөрт нь тийм боломж байгаа бол энэхүү гэрээг цаашид хэрэгжүүлэх үүднээс цөмийн зэвсгийн хэрэглээ, эсхүл туршилтад өртсөн Оролцогч улсуудад техникийн, материалын болон санхүүгийн тусламж үзүүлнэ.

4. Оролцогч улс бүр өөрт нь тийм боломж байгаа бол цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмж хэрэглэх, туршихад өртсөн хохирогчдод тусламж үзүүлнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
ГАЗАР БИРЭН ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2014 оны 10 сарын 23 дөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

5. Энэ зүйлд заасан тусламжийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын систем, олон улсын, бүс нутгийн, эсхүл үндэсний байгууллага, эсхүл институт, төрийн бус байгууллага, эсхүл институт, Олон улсын Улаан загалмайн хороо, Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоо, эсхүл үндэсний Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдээр дамжуулан, эсхүл хоёр талын үндсэн дээр үзүүлнэ.

6. Олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн аливаа өөр үүрэг, хариуцлагад сөрөг нөлөөлөхгүйгээр, цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмж хэрэглэсэн, эсхүл туршсан Оролцогч улс хохирогчдод тусламж үзүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх зорилгоор тийм өртсөн Оролцогч улсуудад зохих тусламж үзүүлэх үүрэгтэй.

8 дугаар зүйл Оролцогч улсуудын уулзалт

1. Энэхүү гэрээний холбогдох заалтуудын дагуу гэрээг хэрэглэх, хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудлыг авч хэлэлцэх, шаардлагатай бол шийдвэр гаргах, цөмийн зэвсгийг хураах талаар цаашид авах дараах арга хэмжээг хэлэлцэх зорилгоор Оролцогч улсуудын уулзалтыг тогтмол хийнэ. Үүнд:

(а) Энэхүү гэрээний хэрэгжилт ба нөхцөл байдал;

(б) Цөмийн зэвсгийн хөтөлбөрийг магадлан шалгах хяналтын дор тодорхой заасан хугацаанд эргэлт буцалтгүйгээр устгах арга хэмжээ, тэр дундаа энэхүү гэрээний нэмэлт протоколуудын асуудал;


(в) Энэхүү гэрээний заалтуудын дагуу болон тэдгээрт нийцсэн аливаа бусад асуудал.

2. Оролцогч улсуудын анхны уулзалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор зарлан хуралдуулна. Оролцогч улсууд өөрөөр тохиролцоогүй бол Оролцогч улсуудын дараагийн уулзалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хоёр жил тутамд зарлан хуралдуулна. Оролцогч улсуудын анхны уулзалтаас уулзалтын дэгийг батална. Түүнийг батлах хүртэл Цөмийн зэвсгийг хориглох, улмаар түүнийг бүрэн устгахад чиглэсэн заавал дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгийг хэлэлцэн тохиролцох асуудлаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Бага хурлын дэгийг дагаж мөрдөнө.

3. Шаардлагатай гэж үзвэл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Оролцогч улсуудын ээлжит бус уулзалтыг Оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүй хувь нь дэмжсэн Оролцогч аливаа улсын бичгээр гаргасан хүсэлтийн дагуу зарлан хуралдуулна.

4. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дараа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга гэрээний хэрэгжилт, түүний зорилгод хүрэхэд гарсан ахиц дэвшлийг хянан хэлэлцэх бага хурлыг зарлан хуралдуулна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга дараа дараагийн хянан хэлэлцэх бага хурлыг зургаан жил тутам хэрэв Оролцогч улсууд өөрөөр шийдвэрлээгүй бол, тийм зорилгоор зарлан хуралдуулна.

5. Энэхүү гэрээний оролцогч тал болоогүй улсууд, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн холбогдох байгууллагууд, олон улсын бусад холбогдох байгууллага буюу институт, бүс нутгийн байгууллагууд, Олон улсын Улаан загалмай хороо, Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар



нийгэмлэгүүдийн холбоо, холбогдох төрийн бус байгууллагуудыг Оролцогч улсуудын уулзалт, хянан хэлэлцэх бага хуралд ажиглагчаар оролцохыг урина.

9 дүгээр зүйл Зардал

1. Оролцогч улсуудын уулзалт, хянан хэлэлцэх бага хурал, Оролцогч улсуудын ээлжит бус уулзалтын зардлыг Оролцогч улсууд болон тэдгээрт ажиглагчаар оролцох оролцогч бус улсууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын зохих ёсоор хувь тэнцүүлсэн үнэлгээний дагуу хариуцна.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаас энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн дагуу гаргасан мэдэгдлүүд, 4 дүгээр зүйлд заасан тайлангууд, 10 дугаар зүйлийн дагуу санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг тараахад гарах зардлыг Оролцогч улсууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын зохих ёсоор хувь тэнцүүлсэн үнэлгээний дагуу хариуцна.

3. Гэрээний 4 дүгээр зүйлд заасан магадлан шалгах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал, мөн цөмийн зэвсэг, эсхүл цөмийн бусад төрлийн тэсрэх төхөөрөмжийг устгах, цөмийн зэвсгийн хөтөлбөр, тэр дундаа цөмийн зэвсэгтэй холбоотой бүх байгууламжийг устгах, эсхүл хөрвүүлсэнтэй холбоотой зардлыг тэдгээрт хамаарах Оролцогч улс хариуцна.

10 дугаар зүйл Нэмэлт, өөрчлөлт оруулах

1. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ямар ч үед, аль ч Оролцогч улс гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Санал болгож буй нэмэлт, өөрчлөлтийн бичвэрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлэх бөгөөд тэрээр түүнийг Оролцогч бүх улсад тарааж, уг саналыг хэлэлцэх эсэх талаар тэдний саналыг авна. Хэрэв Оролцогч улсуудын олонх нь түүнийг хэлэлцэхийг дэмжиж байгаагаа санал хүргүүлснээс хойш 90 хоногийн дотор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдвэл уг саналыг Оролцогч улсуудын дараагийн уулзалт, эсхүл хянан хэлэлцэх бага хурлын аль түрүүнд болохоор нь авч хэлэлцэнэ.

2. Оролцогч улсуудын уулзалт, эсхүл хянан шалгах бага хурал нь нэмэлт, өөрчлөлтийг Оролцогч улсуудын гуравны хоёрын саналаар батлах замаар хэлэлцэн тохиролцож болно. Гэрээний эх хадгалагч нь батлагдсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг Оролцогч бүх улсад хүргүүлнэ.

3. Нэмэлт, өөрчлөлт нь түүнийг батлахад дэмжсэн Оролцогч улсуудын олонх нь нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн тухай батламж жуух бичгээ хадгалуулснаас хойш 90 хоногийн дараа батламж жуух бичгээ хадгалуулсан Оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болно. Улмаар Оролцогч аливаа бусад улсын хувьд нэмэлт, өөрчлөлт нь тухайн улс түүнийг соёрхон баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн тухай батламж жуух бичгээ хадгалуулснаас хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

11 дүгээр зүйл Маргааныг шийдвэрлэх

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МОН

Гарын үсэг /Signature/

2014 оны 06 сарын 09 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

1. Энэхүү гэрээг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдуулан хоёр буюу түүнээс дээш Оролцогч улсын хооронд маргаан үүсэх тохиолдолд холбогдох талууд маргааныг яриа хэлэлцээний, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 33 дугаар зүйлд заасны дагуу өөрсдийн сонгосон эв зүйн бусад аргыг сонгох замаар зөвлөлдөнө.

2. Оролцогч улсуудын уулзалт нь сайн санааны туслалцааг санал болгох, Оролцогч улсуудын өөрсдийнх нь сонгон тохиролцсон зохицуулах журмыг хэрэгжүүлж эхлэхийг тэдэнд уриалах, энэхүү гэрээ болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн холбогдох заалтуудын дагуу тохиролцсон аливаа журмыг хэрэгжүүлэх цаг хугацааны хязгаарыг санал болгох зэргээр маргааныг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулж болно.

**12 дугаар зүйл.
Түгээмэл байдал**

Энэхүү гэрээг бүх улс дагаж мөрдөх зорилготой нийцүүлэн Оролцогч улс бүр энэхүү гэрээнд оролцогч бус улсуудыг гэрээнд гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсхүл нэгдэн орохыг уриална.

**13 дугаар зүйл
Гарын үсэг зурах**

Энэхүү гэрээ нь 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн Нью-Йорк хот дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Төв байранд бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

**14 дүгээр зүйл
Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох**


Энэхүү гэрээнд гарын үсэг зурсан улсууд нь гэрээг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батална. Гэрээнд нэгдэн ороход нээлттэй байна.

**15 дугаар зүйл
Хүчин төгөлдөр болох**

1. Энэхүү гэрээ нь соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай тавь дахь батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай тавь дахь батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг хадгалуулах аливаа улсын хувьд энэхүү гэрээ нь тухайн улсаас соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай батламж жуух бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

16 дугаар зүйл



Тайлбар хийх

Энэхүү гэрээний зүйлд тайлбар хийхгүй.

17 дугаар зүйл Гэрээний хугацаа ба гэрээнээс гарах

1. Энэхүү гэрээ нь хугацаагүй үйлчилнэ.
2. Оролцогч улс бүр өөрийн үндэсний тусгаар тогтнолыг хэрэгжүүлэх үүднээс энэхүү гэрээтэй холбоотой онцгой нөхцөл байдал нь тухайн улсын язгуур эрх ашгийг хохироосон гэж үзвэл гэрээнээс гарах эрхтэй. Тухайн улс нь гэрээнээс гарсан тухай мэдэгдлийг Гэрээний эх хадгалагчид өгнө. Тийм мэдэгдэлдээ өөрийн улсын язгуур эрх ашгийг хохироосон гэж үзэж буй онцгой нөхцөл байдлын тухай дурдана.
3. Гэрээнээс гарсан тухай мэдэгдлийг Гэрээний эх хадгалагч хүлээн авснаас хойш 12 сарын дараа уг мэдэгдэл нь хүчин төгөлдөр болно. Гэсэн хэдий ч хэрэв тухайн 12 сар дуусах хүртэлх хугацаанд гэрээнээс гарч буй Оролцогч улс нь зэвсэгт мөргөлдөөнд оролцогч тал болсон тохиолдолд Оролцогч тухайн улс цаашид зэвсэгт мөргөлдөөнд оролцогч тал биш болох хүртлээ энэхүү гэрээний болон бусад нэмэлт протоколд заасан үүргээ үргэлжлүүлэн хүлээнэ.

18 дугаар зүйл Бусад гэрээний харилцаа

Энэхүү гэрээг хэрэгжүүлэх нь Оролцогч улсуудын өмнө нь нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь, ингэхдээ тэдгээр нь тус гэрээнд нийцсэн тохиолдолд, сөргөөр нөлөөлөхгүй.

19 дүгээр зүйл Гэрээний эх хадгалагч

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргыг энэхүү гэрээний эх хадгалагчаар үүгээр томилов.

20 дугаар зүйл Эх бичвэрийн адил хүчинтэй байдал

Энэхүү гэрээний араб, хятад, англи, франц, орос болон испани хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Нью-Йорк хотноо 2017 оны 7 дугаар сарын 7-ны өдөр үйлдэв.

